



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/03/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: gereltekhburtgelaudit03@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	7
4. Аудитын тайлан.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Дотоод хяналт.....	9
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
4.4 Материаллаг байдал.....	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт.....	12
8.1 Төлбөрийн акт.....	13
8.2 Албан шаардлага.....	14
8.3 Зөвлөмж.....	15
9.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НӨАУГ	Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.16 № 140

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дөрвөлж ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн менежментийн захидалд дурдсан бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, урт хугацаат өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь толилуулаагүй, авлагын зарим хэсэг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд байгууллагын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		2021 оны 1-р сарын 01	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,196,468.82	57,804,080.69
1.1.2	Дансны авлага	821,573,831.17	1,515,376,225.23
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	253,782,036.82	59,264,500.19
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	306,060,890.04	236,917,199.26
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	140,298,827.80	148,976,747.76
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,532,912,054.65	2,018,338,753.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	13,593,919,061.09	13,367,593,520.12
1.2.2	Биет бус хөрөнгө	1,289,713,371.71	1,285,580,773.45
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,883,632,432.80	14,653,174,293.57
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,416,544,487.45	16,671,513,046.70
2.1.1.1	Дансны өглөг	423,394,068.82	224,573,448.30
2.1.1.3	Татварын өр	197,071,910.92	95,086,938.69
2.1.1.5	Богино хугацаат зээл	269,999,998.88	150,000,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	13,468,827.10	9,780,564.46
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	10,513,224.92	2,738,098.45
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	914,448,030.64	482,179,049.90
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	4,394,051,414.99	4,394,051,414.99
2.1.2.5	Хойшлогдсон орлого	1,904,676,045.13	3,351,834,020.33
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,298,727,460.12	7,745,885,435.32
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,213,175,490.76	8,228,064,485.22
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	17,891,641,028.25	17,891,641,028.25
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	231,207,181.31	236,955,957.55
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(8,919,479,212.87)	(9,685,148,424.32)
2.3.10	Тайлант үеийн ашиг алдагдал	(570,174,767.37)	(1,335,843,978.82)
	Өмнөх үеийн ашиг алдагдал	(8,349,304,445.50)	(8,349,304,445.50)
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,203,368,996.69	8,443,448,561.48
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,416,544,487.45	16,671,513,046.70

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,499,642,932.76	6,630,648,368.22
2	Борлуулалтын өртөг	(6,618,393,146.14)	(7,408,482,355.64)
3	Нийт ашиг(алдагдал)	(1,118,750,213.38)	(777,833,987.42)
4	Түрээсийн орлого	11,545,454.50	20,988,181.74
5	Хүүгийн орлого	104,715.05	
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,240,333,009.63	1,134,142,139.85
9	Борлуулалт, маркетингийн зардал	(147,426,140.18)	(175,875,374.04)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(384,857,236.10)	(389,302,731.36)
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	(8,859,070.00)	(23,186,405.78)

Сүхбаатар аймгийн Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(149,201,596.29)	(553,760,208.37)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(557,111,076.77)	(764,828,385.38)
19	Орлогын татварын зардал	(13,063,690.60)	(840,826.07)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(570,174,767.37)	(765,669,211.45)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(570,174,767.37)	(765,669,211.45)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(570,174,767.37)	(765,669,211.45)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	(570,174,767.37)	(765,669,211.45)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	17,891,641,028.25	231,207,181.31	(8,349,304,445.5)	9,773,543,764.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(570,174,767.37)	(570,174,767.37)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	17,891,641,028.25	231,207,181.31	(8,919,479,212.87)	9,203,368,996.69
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(765,669,211.45)	(765,669,211.45)
Өмчид гарсан өөрчлөлт		5,748,776.24		5,748,776.24
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	17,891,641,028.25	236,955,957.55	(9,685,148,424.32)	8,443,448,561.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,337,337,882.74	8,303,007,294.16
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,676,240,800.60	6,694,275,392.65
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	15,039,755.00	21,310,939.50
	Татаас, санхүүжилтийн орлого	510,000,000.00	415,736,979.00
	Бусад мөнгөн орлого	1,136,057,327.14	1,171,683,983.01
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(6,958,374,415.53)	(8,001,922,373.32)
	Ажиллагчдад төлсөн	(1,552,607,558.07)	(1,456,503,845.27)
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(558,897,669.16)	(568,996,094.29)
	Бараа материал худалдан авахад төлсөн	(1,575,415,931.88)	(1,691,525,538.65)
	Ашиглалтын зардалд төлсөн	(701,412,816.97)	(785,285,342.90)
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(703,360,806.67)	(819,101,220.17)
	Хүүгийн төлбөрт төлсөн	(51,301,769.10)	(16,962,105.59)
	Татварын байгууллагад төлсөн	(912,779,797.70)	(785,662,673.83)
	Даатгалын төлбөрт төлсөн	(16,626,020.00)	(7,149,367.00)
	Бусад мөнгөн зарлага	(885,972,045.98)	(1,870,736,185.62)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	378,963,467.21	301,084,920.84
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(391,991,703.47)	(254,477,308.97)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(391,991,703.47)	(254,477,308.97)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(391,991,703.47)	(254,477,308.97)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(13,028,236.26)	46,607,611.87

Сүхбаатар аймгийн Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,224,705.08	11,196,468.82
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,196,468.82	57,804,080.69

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
А	Дулааны орлого	4,378,615,709.70	4,855,579,000.00	5,211,686,334.59	356,107,334.59	107.3
	Хэрэгцээний халуун усны орлого	114,604,915.45	49,786,800.00	54,464,580.00	4,677,780.00	109.4
	Цэвэр усны орлого	527,994,901.98	599,618,500.00	654,146,749.99	54,528,249.99	109.1
	Бохир ус зайлуулсны орлого	206,033,840.72	276,512,000.00	296,326,916.36	19,814,916.36	107.2
Б	Түрээсийн орлого	11,545,454.50	11,900,000.00	20,988,181.74	9,088,181.74	176.4
	Засвар үйлчилгээний орлого	16,101,814.14	13,670,000.00	20,240,501.64	6,570,501.64	148.1
	Бараа борлуулсны орлого	252,116,386.86	301,550,000.00	393,783,285.64	92,233,285.64	130.6
В	Гэрээт ажлын орлого	1,240,333,179.18	880,228,300.00	949,272,250.88	69,043,950.88	107.8
	Бусад орлого	4,175,194.36		28,543,682.86	28,543,682.86	
	Хойшлогдсон орлого	104,715.05		156,326,206.11	156,326,206.11	
	Нийт дүн	6,751,626,111.94	6,988,844,600.00	7,785,778,689.81	796,934,089.81	104.4
	Цалин хөлс	1,794,547,425.09	2,001,787,500.00	2,027,589,156.66	(25,801,656.66)	101.3
	НДШ-ийн зардал	286,911,404.20	315,353,000.00	320,453,879.47	(5,100,879.47)	101.6
	Албан татвар хураамж /УХЭХ, газар, автотээвэр, татвар бусад/	2,920,768.00	12,003,900.00	15,529,401.29	(3,525,501.29)	129.4
	Бичиг хэргийн зардал	4,644,680.94	8,842,200.00	8,498,471.56	343,728.44	96.1
	Нүүрсний зардал	974,486,490.52	923,411,600.00	900,257,459.69	23,154,140.31	97.5
	Хангамжийн материалын зардал	842,688,059.07	990,141,800.00	1,176,513,041.10	(186,371,241.10)	118.8
	Цахилгааны зардал	524,361,827.35	592,169,400.00	559,850,267.72	32,319,132.28	94.5
	Сургалтын зардал	3,572,830.00	6,022,000.00	19,009,423.45	(12,987,423.45)	315.7
	Тээврийн зардал	106,520,355.22	77,831,400.00	71,223,026.55	6,608,373.45	91.5
	Тогтмол үйлчилгээ, засвар	62,196,483.44	39,165,200.00	33,662,671.00	5,502,529.00	86.0
	Шатахууны зардал	229,721,772.99	245,202,000.00	221,617,698.95	23,584,301.05	90.4
	Даатгалын зардал	12,523,145.00	7,500,000.00	8,999,572.00	(1,499,572.00)	120.0
	Шуудан холбооны зардал	16,557,501.90	19,399,900.00	14,708,918.37	4,690,981.63	75.8
	Хоолны хөнгөлөлт	16,896,700.00	79,817,800.00	73,635,200.00	6,182,600.00	92.3
	Томилолт /унаа, буудал, хоол/	59,980,462.00	23,902,500.00	21,597,572.73	2,304,927.27	90.4
	Баяр ёслол, соёлын арга хэмжээ	15,034,680.01	4,254,400.00	7,514,492.72	(3,260,092.72)	176.6
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал	92,389,114.10	110,004,500.00	166,823,271.00	(56,818,771.00)	151.7
	Банкны үйлчилгээний зардал /зээлийн хүү, шимтгэл/	35,262,635.39	14,657,500.00	21,218,912.02	(6,561,412.02)	144.8
	Элэгдэлийн зардал	1,522,816,057.23	1,695,221,100.00	1,718,588,604.48	(23,367,504.48)	101.4
	Зар сурталчилгааны зардал	14,848,528.70	8,300,800.00	11,882,645.46	(3,581,845.46)	143.2
	Хөдөлмөр хамгааллын зардал	134,388,068.83	106,967,500.00	99,667,025.02	7,300,474.98	93.2
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	63,863,258.39	47,068,400.00	66,554,175.61	(19,485,775.61)	141.4
	Бусад зардал	104,129,544.05	33,283,000.00	41,730,089.56	(8,447,089.56)	125.4
	Үйл ажиллагааны бус зардал					
	ҮХ данснаас хассан гарц	149,201,596.29		553,229,598.78	(553,229,598.78)	
	ҮАБус бусад зардал	238,273,800.00	302,155,800.00	390,252,500.00	(88,096,700.00)	129.2
	Нийт дүн	7,308,737,188.71	7,664,463,200.00	8,550,607,075.19	(886,143,875.19)	111.6

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дөрвөлж ОНӨААТҮГ-ын зорилго нь “Баруун урт хотын хүн амыг ус, дулаанаар найдвартай хангаж, орчин үеийн дэвшилтэт технологи, аюулгүй ажиллагааг эрхэмлэсэн мэргэжлийн байгууллага болоход оршино” гэжээ.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай гэрээ байгуулсан орон сууцны айл өрх, төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийг дулааны эрчим хүчээр тогтоосон халаалтын улиралд температурын графикайн дагуу жигд тасралтгүй хангах
- Хүн ам, Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай гэрээ байгуулсан үйлдвэр, аж ахуйн нэгжийн усны хэрэгцээг стандартын шаардлага хангасан цэвэр усаар тасралтгүй хангаж, чанарын хяналт хийх
- Ахуйн болон үйлдвэрийн бохирдсон усыг татан зайлуулж зохих стандарт шаардлагын дагуу цэвэрлэж байгальд нийлүүлэх
- Хэрэглэгчийн дулааны эрчим хүч, усны алдагдлыг бууруулах, цэвэр, бохир усанд стандартын дагуу лабораторийн шинжилгээ хийх
- Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын барилга байгууламж, шугам сүлжээ, эх үүсвэр, машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, өргөтгөл, шинэчлэлт хийх, зохистой техник технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг зохих журмын дагуу авах
- Үйлчлүүлэгчийн хүсэлт захиалгаар тэдний эзэмшилд байгаа дулааны болон ус сувгийн шугам сүлжээ, сантехникийн эвдрэл гэмтэлд мэргэжлийн туслалцаа үзүүлж, засвар үйлчилгээг төлбөртэйгээр хийж гүйцэтгэх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дөрвөлж ОНӨААТҮГ нь 1962 онд Сүхбаатар аймгийн Баруун урт хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны харьяа Үйлчлэх товчоо нэртэйгээр байгуулагдсан. 2002 онд Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2002 оны 20 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 126 дугаар захирамжаар Ус сувгийн газар, дулаан хангамжийг нэгтгэн Дөрвөлж ОНӨААТҮГ болон бүтэц зохион байгуулалт нь өөрчлөгдсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй: ... 5/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;...” гэсэн заалттай нийцэж байна.

Дөрвөлж ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийн бүрэлдхүүнийг Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 24 дугаар тогтоолоор томилсон байна.

Дөрвөлж ОНӨААТҮГ-ын Гүйцэтгэх захирлыг Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Б/81 дугаар тушаалаар томилсон байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, СБА-2022/03/НА-СТА-ТШЗ

календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дөрвөлж ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,196.5	57,804.1	46,607.6
БХХО			
Авлага	1,075,355.9	1,574,640.7	499,284.8
Урьдчилгаа	140,298.8	148,976.7	8,677.9
Бараа материал	306,060.9	236,917.2	69,143.8
Үндсэн хөрөнгө	13,593,919.1	13,367,593.5	226,325.6
Биет бус хөрөнгө	1,289,713.4	1,285,580.8	4,132.6
Нийт хөрөнгийн дүн	16,416,544.5	16,671,513.0	254,968.6
Өр төлбөрийн дүн	644,448.0	332,179.1	312,268.9
Богино хугацаат зээл	269,999.9	150,000.0	119,999.0
Урт хугацаат өглөг	4,394,051.4	4,394,051.4	-
Хойшлогдсон орлого	1,904,676.0	3,351,834.0	1,447,158.0
Эздийн өмч	9,203,368.9	8,443,448.6	759,920.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,416,544.5	16,671,513.0	254,968.6

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 48.1, харилцах дансны эцсийн үлдэгдэл 57,755.9, нийт 57,804.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 1,574,640.7 мянган төгрөг болж, 499,284.8 мянган төгрөгөөр өссөн нь Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дугаар тогтоолоор ус, дулааны төлбөрийг төрөөс хариуцан төлөхтэй холбоотой Эрчим хүчний яамнаас авах 561,304.5 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд тайлант онд өөрчлөлт ороогүй, он дамжсан 306,037.1 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 148,976.7 мянган төгрөг болж, 8,677.9 мянган төгрөгөөр өссөн нь 2 бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгж байгууллагаас авах худалдан авалтад урьдчилгаа төлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 236,917.2 мянган төгрөг болж 69,143.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны бараа материалын зарцуулалтаас, ашиглалтгүй 10,474.2 мянган төгрөгийн бараа материалыг актлан данснаас хассанаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 102 ширхэг 211,393.1 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 13,367,593.5 мянган төгрөг болж, 226,325.6 мянган төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Худалдан авсан 437,972.3 мянган төгрөгийн, Капитал банкнаас ус дулааны авлагын оронд авсан 434.2 мянган төгрөгийн, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 78 дугаар тогтоолоор үнэ төлбөргүй шилжин ирсэн 1,603,484.2 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгджээ.

Үндсэн хөрөнгийн данс Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 4 удаагийн тогтоолоор 1,486,542.7 мянган төгрөгийн хөрөнгийг, Аймгийн орон нутгийн өмчийн даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 623 дугаар албан бичгээр 15,735.1 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус акталснаар хасагджээ.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 1,285,580.8 мянган төгрөг болж, 4,132.6 мянган төгрөгөөр буурсан нь Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны тогтоолоор 2,178.0 мянган төгрөгийн 2 ширхэг программ хангамжийг аклан данснаас хассанаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 332,179.1 мянган төгрөг болж, 312,268.9 мянган төгрөгөөр буурсан нь ААНОАТ болон ХХОАТ-ын өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулсан нь голлон нөлөөлжээ.

Ажилчдын 25 айлын орон сууцыг барих зориулалтаар 2021 онд Хаан банкнаас жилийн 14.4 хувийн хүүтэй, 300,000.0 мянган төгрөгийн зээлийг авч, богино хугацаат зээлийн дансанд тусгасан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна. Монгол улсын Их хурлаас 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн II үе шатны зээл"-ийн төслийг хэрэгжүүлэх зорилгоор Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газартай 2003 оны 12 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан MON (SF)-1907 дугаартай дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу зээлийн эргэн төлөлт хийгдээгүйгээс урт хугацаат өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэлд 8 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 4,069,274.9 мянган төгрөгийн, Дөрвөлж ОНӨААТҮГ-т өгөх 324,776.5 мянган төгрөгийн, нийт 4,394,051.4 мянган төгрөгийн он дамжсан өр төлбөр бүртгэлтэй байна. Энэ нь 2006 онд Баруун урт хотод Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хийгдсэн дулаан, цэвэр, бохир усны сүлжээг шинэчилсэн, мөн дагалдах тоног төхөөрөмж нэмж суурилуулсантай холбоотой байна.

Гэрээнд зааснаар зээлийн ашиглаад төлөгдөөгүй байгаа үндсэн өрийн үлдэгдэлд жилийн 4.5 хувийн хүүг зээл төлөх тухайн өдрийн Монгол банкны албан ханшаар тооцоолон бүртгэлд тусгаагүй, үндсэн өр төлбөр, хүү, алданги төлөх эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн байна. Мөн Засаг даргын Тамгын газартай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дөрвөлж ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Дөрвөлж ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийн 2021 оны 01 дүгээр тушаалаар компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 6,988,844.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 7,664,463.2 мянган төгрөгөөр, 675.6 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан-төлөвлөгөө гүйцэтгэл
/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	6,751,626.10	6,988,844.60	7,785,778.70	-796,934.10	104.4
	Үүнээс: Цэвэр					

	борлуулалт					
2	Нийт зардал	7,308,737.20	7,664,463.20	8,550,607.10	-886,143.90	96.2
	Үүнээс:					
	а) Ерөнхий ба удирдлагын зардал	384,857.20	394,593.70	389,302.70	5,291.00	98.4
3	Цэвэр ашиг, алдагдал	-557,111.10	-675,618.60	-764,828.40	89,209.80	

Гүйцэтгэлээр 7,785,778.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 8,550,607.1 мянган төгрөгийн зардал гарган, 764,828.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 7,785,778.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 796,934.1 мянган төгрөг буюу 104.4 хувиар давсан нь айл өрхийн халаалтын тариф нэмэгдсэн, халаалтын хугацаа урагшилсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 8,550,607.1 мянган төгрөг болж, 885,643.9 мянган төгрөгөөр буюу илүү буюу 111.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг актлан данснаас хассантай холбоотой гарз үүссэн, үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой элэгдлийн зардал өссөн, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төслөөр бохирын цэвэрлэх байгууламж ашиглалтад орохтой холбоотойгоор хүний нөөцийг бэлтгэх хүрээнд 4 ажилтны сургалтын зардал нэмэгдсэн, хангамжийн материалын үнийн өсөлт, төлөвлөгдөөгүй гэрээт ажил нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 9 нэр төрлийн 100 ажил төлөвлөснөөс 9 нэр төрлийн 92 ажил хийж гүйцэтгэсэн 92 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Өөрийн эх үүсвэрээс 605,200.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 764,828.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 89,209.8 мянган төгрөгөөр илүү байгаа нь нийт зардлын гүйцэтгэл 885,643.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн буюу 111.6 гүйцэтгэлтэй байгаагаас шалтгаалжээ.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовн туслах Э.Алтангэрэл, аудиторовн туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа, Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн Чанарын хяналтын менежер Д.Батмөнх, Захирал А.Сарангэрэл нар хэрэгжүүлсэн.

Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан тодруулгыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 06/48 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд компанийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дөрвөлж ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоос 2.0 хувиар буюу 135,032.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 108,026.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дөрвөлж ОНӨААТҮГ нь 2021 онд нийт 11,529,762.6 мянган төгрөгийн 410 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 7,305,148.2 мянган төгрөгийн 261 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан үйл ажиллагаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан асуудлыг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6.1. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 10.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, дотоод хяналт, авлага өр төлбөртэй холбоотой 3 зөвлөмж өгснөөс акт 100.0 хувь, албан шаардлага 0 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	-	-	1	-	-
Төлбөрийн акт	1	10.7	1	10.7	1	-	-
Зөвлөмж	3	-	3	-	-	-	-
Нийт дүн	5	10.7	4	10.7	1	-	-

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулсан эсэх, урт хугацаат өр төлбөр, авлагын данстай холбоотой асуудлыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,417,546.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12,782.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 647.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт, 1,597,990.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 7,806,126.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дугаар тогтоолоор ус, дулааны төлбөрийг төрөөс хариуцан төлөхтэй холбоотой Эрчим хүчний яамнаас авах дулааны авлагыг 361,010.7 мянган төгрөгөөр тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулсан, санхүүгийн тайланд авлагын үлдэгдлийг 373,793.1 мянган төгрөгөөр тусган тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар”, баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж,

санхүүгийн тайлан гаргах", "эрх ба үүрэг", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд Эрчим хүчний яамнаас авах дулааны авлагыг 12,782.4 мянган төгрөгөөр бууруулж, 361,010.7 мянган төгрөгөөр бүртгэн тайлагнасан.

8.2 Төлбөрийн акт

Цалинг буруу тооцож олгосонтой холбоотой нийт 647.3 мянган төгрөгийн алдаа зөрчилтэй байна. Үүнд:

1. *Хөдөлмөрийн чадвар алдсаны акттай 1 ажилтны цалингаас ХХОАТ чөлөөлөлгүй тооцоноос 46.4 мянган төгрөгийг илүү суутгасан;*

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д "Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна", "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", 25 дугаар зүйлийн 25.3-т "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. *Давхар ажил эрхэлдэг 1 ажилтны 10 дугаар сарын цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцоноос 18.0 мянган төгрөгийг дутуу суутгасан;*

3. *Нийт 19 ажилтны 8-10 дугаар сарын цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт илүү тооцоноос 582.8 мянган төгрөгийг дутуу суутгасан*

ХХОАТ-ын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1-д " Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна", 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", "7.1.6-д "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

8.3 Албан шаардлага

Нийт 28 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 57,746.3 мянган төгрөгийн, 44 хувь хүмүүстэй холбоотой 46,896.7 мянган төгрөгийн, нийт 104,642.0 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны СБА-2022/03/НА-СТА-ТШЗ

байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “ үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

2. Байгууллага нь 872,844.5 мянган төгрөгийн нүүрс, 590,412.5 мянган төгрөгийн шатахуун, 30,090.0 мянган төгрөгийн ажлын хувцас нийт 1,493,347.1 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй бэлтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2 “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.4 “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, 46 дугаар зүйлийн 46.1.5 “энэ хуулийн 7.6-д зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх”, 48 дугаар зүйлийн 48.5 “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урт хугацаат өр төлбөрийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

МУЗГ болон Азийн хөгжлийн банкны хооронд 2002 оны 09-р сарын 05-ны өдөр байгуулсан “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны MON(SF)-1907” тоот гэрээ байна. Уг гэрээний хүрээнд Аймгийн ЗДТГ, Дөрвөлж ОНӨААТҮГ-ын хооронд дамжуулан зээлдүүлэх гэрээ хийгдсэн бөгөөд байгууллагын санхүүгийн тайлан дээр толилуулагдсан 4,394,051.4 мянган төгрөгийн урт хугацаат өр төлбөр юм. Гэтэл Монгол Улсын Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01-р сарын 27-ны өдрийн 8-3/417 тоот албан бичгээр тус гэрээний дагуу 4.2 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн төлбөр, тооцоолсон алданги 25.1 тэрбум төгрөгт хүрсэн талаар мэдэгдэл ирсэн байна. Үүнээс тус байгууллагатай холбоотой УХӨТ-ыг санхүүгийн тайланд үнэн зөв толилуулаагүй, үндсэн төлбөр, хүү, алданги төлөх эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн байна. Хууль журмын дагуу Засаг даргын Тамгын газартай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,,” заалт, мөн хуулийн 20.2.6-д заасан “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Урт хугацаат өр төлбөрийг төлж барагдуулах талаарх асуудлыг холбогдох байгууллагуудад хүсэлт гарган хууль эрх зүйн актын хүрээнд шийдвэр гаргуулаагүй, он дамжсан байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Өр төлбөр үүсэх ажил гүйлгээ гарч төлөх хэмжээ нь баримтаар нотлогдсоныг дахин тодорхойлох, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, урт хугацаат өр төлбөрийг төлж барагдуулаагүй шалтгааныг холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлах, асуудлыг шийдвэрлэх

2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Авлагын үлдэгдэлд тайлант онд өөрчлөлт ороогүй, он дамжсан 306,037.1 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй, үүнээс 16,452.1 мянган төгрөгийн авлагыг шүүх хяналтын байгууллагад шилжүүлсэн, үлдсэн 289,584.9 мянган төгрөгийн авлагын эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлага барагдуулах арга хэмжээ хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,," заалт, мөн хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журмыг мөрдөн ажиллах, үүссэн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж баримтжуулах, авлагыг барагдуулах арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнах

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Хангамжийн материалын дансанд хөдөлгөөн ороогүй, ашиглахаа больсон 102 ширхэг 211,393.61 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", УСНББОУС 12 Бараа материал-ын үндсэн шаардлага, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын үлдэгдэлд дахин тооллого хийж, холбогдох саналыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж, шийдвэрлэх

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Байгууллагын дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 280 ширхэг 788,619.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1 "элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон" заалт, УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-д тавигдах шаардлага, "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоож, холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

5. Шилэн данстай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 11,529,762.6 мянган төгрөгийн 410 мэдээллийг ил тод байршуулахаас 7,305,148.2 мянган төгрөгийн 261 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4

дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдээдлийг хангахгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Санхүүгийн тайланд авлагыг тооцоо нийлсэн актаас зөрүүтэй тайлагнасан	1	12,782.3	1	12,782.3						
2	Цалинг буруу тооцоолон олгосон	1	647.3			1	647.3				
3	Худалдан авалтыг татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдоогүй	1	104,643.0					1	104,643.0		
4	Хангамжийн материалын эхний эцсийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй он дамжсан үлдэгдэлтэй	1	211,393.1							1	211,393.1
5	Он дамжсан тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага бүртгэгдсэн	1	289,585.0							1	289,585.0
6	Урт хугацаат өр төлбөрийн он дамжсан үлдэгдэлтэй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үндсэн өр, хүү, алданги төлөх эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн	1	-							1	-
7	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		7	619,050.7	1	12,782.3	1	647.3	1	104,643.0	4	500,978.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулан олж бэлтгээгүй	1	1,493,347.1					1	1,493,347.1		
2	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	7,305,148.2							1	7,305,148.2
Дүн		2	8,798,495.3	-	-	-	-	1	1,493,347.1	1	7,305,148.2
Нийт дүн		9	9,417,546.0	1	12,782.3	2	647.3	2	1,597,990.1	5	7,806,126.3